



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Энхтайваны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр, Б корпус.

Утас/Факс: (976-51) 26 00 62,

И-мэйл: info@spa.gov.mn, Вэбсайт: www.spa.gov.mn

2020. 05. 29 № A-1/940.  
танай —ны № —т

Г Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас 2020 оны 5 дугаар сарын 12-ны өдөр зарласан XII.2.1.70 “Соёлын төвийн барилга /Дундговь, Дэлгэрцогт сум/” төсөл, арга хэмжээний ажлын зураг, төсөвтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгын дагуу тендерийн нээлт хийх хугацааг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4-д “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах”-аар заасан бөгөөд Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд уг төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 1,000,000,000.00 /нэг тэрбум/ төгрөгөөр санхүүжүүлэхээр тогтоосон.

Дээрх төсөл, арга хэмжээний зураг төсөл нь эрх бүхий байгууллагаар магадлал хийгдэж баталгаажсан тул уг зураг төслийг баримтлан, ажлын тоо хэмжээг тооцоолж, шаардлагатай гэж үзвэл ажлын талбайтай танилцан, зураг төсөвт тусгагдсан ажлын тоо хэмжээний дагуу тендер ирүүлэхийг мэдэгдье.

Энэхүү тодруулгатай холбогдуулан тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд дараах өөрчлөлтийг оруулж байна.

- ТОӨЗ 2.1 Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: 2020 оны 6 дугаар сарын 04-ний өдөр. Цаг: 09 цаг 00 минут
- ТОӨЗ 2.2 Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: 2020 оны 6 дугаар сарын 04-ний өдөр. Цаг: 09 цаг 10 минут
- ТОӨЗ 3.1 (и) Тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа нь: 2020 оны 8 дугаар сарын 01-ний өдрийг дуустал.

Хавсралт: 1 хуудас.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙН  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭГТГЭГЧ



Х.УЛАМ-ӨРНӨХ

ТХААГ-2020-A4